

“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025.6.12

Есөнбулаг сум

“Нээлттэй Засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээний хүрээнд аймагт хийж хэрэгжүүлэх ажлын талаар Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ш.Эрдэнэбат хэлтэс, агентлаг, байгууллагын дарга нарын шуурхай хуралд танилцуулаа. Нээлттэй засгийн түншлэлийг таниулан сурталчлах, мэдлэг ойлголт өгөх ажлын хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Алтансүвд аймгийн төвийн 73 удирдах ажилтанд ERP цахим систем, тоон гарын үсгний хэрэглээний талаар сургалт орлоо. Сургалтаар төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-ын тухай ойлголт, хэрхэн ашиглах, тоон гарын үсгийн хэрэглээний талаар мэдээлэл өгч ажиллалаа.



Төрийн байгууллагуудын мэдээллийн технологи, цахим хариуцсан мэргэжилтэн нарт Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын сургалт хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Цэдэвсүрэн цахим хөгжлийн багц хууль, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын сургалт хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Ууганчимэг Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, Кибер аюулгүй байдлын тухай хууль, журам, хэлтсийн дарга Ж.Даваасүрэн нээлттэй мэдээллийн систем Shilen.gov.mn талаарх

сургалтуудыг тус тус орлоо. Мөн хиймэл оюун ухаан талаарх сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Тус сургалтад оролцсон төрийн албан хаагчид болон иргэд цаг үеэ олсон хэрэгтэй сургалтад оролцсон тухайгаа дурдаж байлаа. Сургалтын мэдээллийг Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар пэйж хуудас, Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн пэйж хуудас, Миний Алтай телевиз зэрэг мэдээллийн сувгаар түгээж ажиллалаа.

“Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээний хүрээнд И-Бизнес платформыг сурталчлан таниулах арга хэмжээнд нэгдэж ажиллалаа. Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс иргэд, аж ахуйн нэгжид зориулсан “И-Бизнес” платформыг сурталчлан таниулах, бизнесийн хариуцлагатай үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, төрийн хүнд суртал, хэт оролцоог бууруулах, авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлэх зорилгоор энэхүү арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.



Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамтай хамтран 18 сумд цахим үйлчилгээний киоск машиныг Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны дарга Д.Батбилэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Насанбуян, аймгийн Засаг дарга Г.Чинбат нар сумдын удирдлагуудад гардуулан өгч төрийн цахим үйлчилгээг түргэн шуурхай болгон ажиллаж байна.



Мөн бүх сумдад хурдан үйлчилгээний цэгийг байгуулж шаардагдах ширээ сандал, компьютер техник хэрэгслээр хангаж хаягжуулалт хийж төрийн цахим үйлчилгээг иргэд түргэн шуурхай чанартай хүргэж шинэ үйлчилгээг нэмэгдүүллээ.

Цахим үйлчилгээний энэхүү дэвшил нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг шинэ шатанд гаргаж, хөдөө орон нутгийн иргэдийн амьдралын чанар, мэдээлэлтэй харьцах боломжийг сайжруулах чухал алхам болж байна.

“Нээлттэй засгийн түншлэлийн 10 үнэт зүйлийн хүрээнд “Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе” хөдөлмөрийн өдөрлөг зохион байгууллаа.

Иргэд олон нийтэд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн багц хуулиудыг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байранд иргэдийг бүртгэх, зуучлах зорилгоор “Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе” өдөрлөгийг аймгийн төвд зохион байгуулан ажиллалаа.

Тус өдөрлөгөөр хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд үзүүлж, мэдээлэл зөвлөгөө өгч дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

☐ Ажилгүй иргэдийг бүртгэж, хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх;

Сул чөлөөтэй ажлын байранд иргэдийг бүртгэж зуучлах;

Ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг иргэдэд хүргэх;

☐ Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн талаар мэдээлэл зөвлөгөөг иргэд өгч ажиллалаа.

Мөн Алтайн баялаг бүтээгчдээ дэмжих зорилгоор “Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, иргэд өөрсдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаанд оролцсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Хүн бүрт боломж бий” өдөрлөгийг зохион байгууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын уядлаа холбоо сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, тэдэнтэй ажилладаг мэргэжилтэн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, хүүхдүүдийг нарийн мэргэжлийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах зорилгоор “Бэрхшээлийг боломж болгоё” нөлөөллийн үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн “Зөвлөх баг”-тай хамтран зохион байгууллаа.



Арга хэмжээний нээлтэд Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, “Хан-Алтай” ресурс ХХК, “Ээлтэй хүүхэд” холбоо ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв зэрэг байгууллагууд оролцлоо.

Хөдөөгийн сумдын иргэдэд явуулын амбулаторийн үзлэг оношилгоог хийж эрт илрүүлэг зохион байгуулан ажиллаж байна. Улаанбаатар хот, аймгийн төвийн нарийн мэргэжлийн эмч нарыг ажиллуулж хөдөөгийн иргэдийн талархлыг хүлээж байна.

Баян-Уул, Хөхморьт, Дарив сумдын зааг нутаг Хүйсийн говьд аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд нээлтэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 1000 гаруй иргэн хамрагдаж төрийн үйлчилгээ авсан байна.



Баян-Уул, Хөхморьт, Дарив сумдын зааг нутаг Хүйсийн говьд аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд нээлтэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 1000 гаруй иргэн хамрагдаж төрийн үйлчилгээ авсан байна.

Аймгийн хэмжээнд хүний эрхийг хангах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомж, шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/474 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын дэргэд “Хүний эрх хамгаалах зөвлөл-ийг” 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан чиг үүргийн дагуу ажиллаж байгаа бөгөөд тус аймгийн 18 сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд 7-9 бүрэлдэхүүнтэй “Хүний эрх хамгаалах” зөвлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутгийн хэмжээнд хүний эрхийг хамгаалах, хангахын тулд Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан аймгийн бодлого төлөвлөлтийг статистик, дүн шинжилгээ, судалгаанд тулгуурлан жендерийн тэгш оролцоотой байх бүх насны иргэд үр нөлөөг нь тэгш шударга хүртэх байдлаар аймгийн батлуулан, хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрт тусгайлан хүний эрхийг хангах тогтолцоог бүрдүүлэх зорилго, зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэхэд тогтвортой, оновчтой, үр өгөөжтэй хөрөнгө оруулалт, бүх түвшний түншлэл хамтын ажиллагааг чухалчлан төрийн хариуцлагыг сайжруулахад анхааран ажиллаж байгаа бөгөөд сумдын бодлого, шийдвэрт мөн адил баримталж байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР